

# Нийгмийн тухай мэдлэг

**БАГШ:Д.ОЮУН**

# Сэдэв 5: Нийгмийн улс төрийн амьдрал

Сэдвийн зорилго: Нийгэм улс төрийн эрх мэдэл, тогтолцоо, бодлого, дэглэм харилцаа, засаглал, эвсэл, намын талаар цэгцтэй мэдлэг олж авахад оршино.

# Түлхүүр үгс:

- Эрх мэдэл
- Арга хэлбэр
- Хуваарилалт
- Тэмцэл
- Засаглал
- Нам
- Бүлэг

Ардчилал нь ард түмнээс сонгогдсон, ард түмний төлөө, ард түмний өөрсдийнх нь засаглал юм.

А. Линкольн

Ардчилал бол хамгийн муу засаглалын хэлбэр, гэхдээ хүн төрөлхтөн үүнээс илүүг хараахан олоогүй байна.

В. Черчилль

1. Улс төр бол зорилт тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх талаар шийдвэр гаргаж, арга хэмжээ авч байдаг улс төрийн бодлого юм.
2. Улс төрийг хүмүүс болон улс төрийн байгууллагуудын засгийн эрхийн төлөө тэмцэл болж байдаг тодорхой хүрээ гэж хэлж болно.
3. Арай өргөн утгаар авч үзвэл улс төр нь хүмүүсийг удирдах урлаг юм.

Францын улс төр судлаач Ф.Бро

Улс төр гэдэг бол эрх мэдэлд хүрэх, эрх мэдлийг тогтоон барьж байх ба ашиг хонжоо олохын тулд эрх мэдлийг ашиглах албадлагын арга хэрэгслийн цогц мөн.

Италийн сэтгэгч Н.Макиавелли



# УЛС ТӨРИЙН ХҮРЭЭНИЙ ТУЛГУУР ОЙЛГОЛТУУД

Улс төрийн тогтолцоо	Нийгмийн бүхий л бүрдэл хэсгүүдийг нэгтгэн нягтруулж, тэдгээрийг төр цөмтэй улс төрийн засаглалаар төвлөрүүлэн удирдаж, нэгдмэл махбод болон оршин байх нөхцөлийг нь хангаж байдаг тогтолцоо мөн.
Улс төрийн бодлого	Улс төрийн эрх мэдэл бүхий байгууллагаас олон түмний түгээмэл эрх ашигт нийцсэн дайчлан гаргах, хуваарилах, зохицуулах, дэмжих чадвар бүхий тасралтгүй үйл явц.
Улс төрийн соёл	Нийгмийн гишүүдийн дийлэнхийн итгэл үнэмшил, дадал заншил, үнэт зүйл бөгөөд тэднээс тухайн улс төрийн систем төр засагт хандах хандлагын илэрхийлэл юм.
Улс төрийн шийдвэр	Улс төрийн үйл ажиллагааны боломжит хувилбаруудаас оновчтой үр дүнтэй хамтын шинжтэй сонгох үйл явц юм.
Улс төрийн харилцаа	Улс төрийн байгууллагууд, субъектүүдийн хооронд үүсдэг эвлэлдэн нэгдэх, зөрчилдөх, сөргөлдөх зэрэг олон талт харилцааны цогц юм.
Улс төрийн дэглэм	Нийгэм дэх улс төрийн харилцаа, засаглалыг хэрэгжүүлэх арга хэлбэр, төр нийгэм хоорондын харилцаа юм.
Улс төрийн ухамсар	Улс төрийн мэдрэмж, ойлголт, уламжлал, үнэлт, дүгнэлт, үзэл санаа, улс төрийн ашиг сонирхол, итгэл үнэмшил, улс төрийн мэдлэг, онол зэргийн нийлбэр цогц юм.

# ЗАСАГЛАЛ, ЭРХ МЭДЭЛ

Засаглал нь : нэр хүнд , эрх мэдэл , албадлага зэрэг олон төрлийн хэрэгслийн тусламжтайгаар нэг хэсэг хүмүүс нийтээр даган мөрдөх ёстой шийдвэр гаргах боломж, чадвараар хангагдах нийгмийн харилцааг хэлнэ.

Улс төрийн засаглал

Төрийн засаглал

## **Засаглалын үндсэн хэмжигдэхүүн**

Засаглалын хэмжээ: Ямар нэг засгийн нөлөө, ач холбогдол, цар хүрээ, хэм хэмжээг

Засаглалын эзлэхүүн : Хичнээн тооны засаглал хэн нэгний , байгууллагын гарт төвлөрч байгааг

Засаглалын цаг хугацаа: Тухайн засаглалын оршин тогтнох хугацааг

Засаглалын орон зай: Тодорхой хэмжээний газар нутагт үйл ажиллагаа явагдаж байгааг

•

Субъект	Объект
<p>Эрх мэдлийн идэвхтэй, хөтлөн чиглүүлэгч шинжийг агуулдаг бөгөөд тушаал, шийтгэл, тогтоосон хэм хэмжээ зэргээр дамжуулан засаглалаа явуулж байдаг, хувь хүн, байгууллага, хүмүүсийн нийтлэг, ард түмэн.</p>	<p>Иргэд, нийгмийн хэсэг бүлэг, нийгмийг бүхэлд нь ч тооцож болно. Субъектээр удирдуулсан албан байгууллагыг засаглалын объектод тооцож болно.</p>

# Эрх мэдлийг тодорхойлох хандлагууд

Германы улс төр судлаач Макс Вебер	Эсэргүүцлийг ялан давж тухайн нийгмийн харилцаанд өөрийн хүсэл зоригийг хэрэгжүүлэх чадвар
Английн философич математикч Б.Рассел	Тавьсан зорилгоо хэрэгжүүлэх чадвар
Америкийн судлаач Т.Парсонс	Тогтолцооны нийтлэг зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн тогтолцооны өөрийнх нь чадвар, нийгмийн бүлгийн өөрсдийгөө зохион байгуулах арга хэрэгсэл
Судлаач Булдинг	Хүмүүс зорилгодоо хүрэхийн тулд эрх мэдлийн хүч хэрэглэх, наймаалцаж, үүрэг үүсгэх хэлбэрүүдийг ашигладаг.

## Эрх мэдлийн ангилал

Багтаамжаар нь

бага (гэр бүл)  
дунд (төрийн)  
өргөн (улс төрийн)

Тусгаарлаж буй  
эх сурвалжаар нь

эдийн засгийн  
мэдээллийн  
албадлагын

Хэрэгжүүлж  
буй аргаар нь

ардчилсан  
ардчилсан бус

Гүйцэтгэж буй  
чиг үүргээр нь

хууль тогтоох  
шүүх  
гүйцэтгэх


Субъектээр нь

гэр бүлийн  
цэргийн  
намын  
үйлдвэрчний  
төрийн

Хэлбэрүүд	Харилцааны төрөл	Захирагдах сэдэл	Байгууламж
Хүч хэрэглэх	Албадлагын хүчээр	Айдас	цагдаа, цэрэг, шүүхийн
Наймаалцах	Ашигтай солилцоогоор	Хожоо	эдийн засгийн
Үүрэг үүсгэх	Хамтын харилцаагаар	Зүтгэх хүсэл	нийгмийн

## Улс төрийн тогтолцооны загвар

### Д. Истоны орц, гарцын онолоор



•

- Сонирхлын бүлгүүд ОНБ - Сонирхол илэрхийлэх
- Улс төрийн нам - Сонирхол нэгтгэх
- Сонирхол хэрэгжүүлэх - Төр

## Улс төрийн хэв маяг

Улс төрийн хэв маягийн Г. Алмондын ангилал:

- Америкийн хэв маяг
- Эх газрын европын хэв маяг
- Аж үйлдвэржихийн өмнөх ба аж үйлдвэржиж буй орны хэв маяг
- Тоталитар хэв маяг

## Улс төрийн бодлого

- Тодорхой зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа төрийн удирдлагын урлагийг харуулах, засгийн төлөвшилтийг илэрхийлэх үйлдлийн цогц мөн

Дотоод

- Нийгмийн анги бүлгүүдийн харилцаа, тэдний нийгмийн статусыг зохицуулна.

Гадаад

- Бусад улс орны төр засагтай харилцах харилцаа, тэдний дунд өөрийн эзлэх байр суурийг зохицуулна.

<b>Засаглалын механизм</b>	<b>Ардчилсан</b>	<b>Дарангуйллын</b>
Засаглалын эх үүсвэр	хууль	Уламжлал, үзэл суртал, хүч хэрэглэх
Удирдах элитийг сонгон шалгаруулах арга	сонгууль	Үе залгамжлах ёс, үзэл суртал, лидерт үнэнч байх
Шийдвэр гаргах арга	олонхийн саналаар	Нэг юмуу цөөн хүний хүслийг бусдад тулгах

## Сонирхлын бүлэг-

Улс төрийн байгууллагаас өөрсөддөө илүү ашигтай, тохиромжтой шийдвэр гаргуулах нийтлэг ашиг сонирхлын үндсэн дээр нэгдэн, хамтран үйл ажиллагаа явуулж буй хүмүүс

- ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮҮРЭГ
- ЛОББИДОХ, ШАХАЛТ ҮЗҮҮЛЭХ ҮҮРЭГТЭЙ
- УХУУЛАН ТАНИУЛАХ ҮҮРЭГТЭЙ

## АШИГ ТУС

- Материаллаг ашиг тус
- Сэтгэл зүйн ашиг тус
- Хүсэл тэмүүллээ гүйцэлдүүлэх

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

- Амралт, чөлөөт цаг
- Эдийн засаг, аж ахуй, үйлдвэрлэгчдийн
- Шинжлэх ухаан, соёл, урлаг, боловсрол
- Социал асуудал болон эрүүл мэндийн
- Үзэл суртал, шашин

## УХУУЛАН ТАНИУЛАХ ҮҮРЭГТЭЙ

- Аномик
- Эвлэл холбооны бус
- Байгууллагажсан
- Эвлэл холбооны

## **УЛС ТӨРИЙН НАМ , НАМЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Нам гэдэг нь засгийн эрхийн төлөө эрмэлзэж, улс төрийн үйл ажиллагаа явуулдаг, тодорхой зохион байгуулалтай улс төрийн байгууллага юм.

### **Улс төрийн намын шалгуур шинжүүд**

- Үндэслэгчээсээ хойш оршин тогтнох чадвараа харуулах
- Удирдах төв аппарат , анхан шатны байгууллагатай байх
- Засгийн эрхийг авахын төлөө эрмэлзэлтэй байх
- Онолын тодорхой үзэл баримтлалтай байх
- Сонгуульд олонхийн саналыг авахыг эрмэлзэнэ.

## Намын онцлог, мөн чанар

- Төрийн эрх авах түүнд ноололох зорилгоор төр олон түмнийг холбож өгдөг
- Үйл ажиллагаа нь хүмүүсийн ухамсар, урам зоригт тулгуурлан явагддаг
- Улс төрийг илүү ардчилсан нээлттэй олон түмэнд хүртээлтэй болгодог
- Тодорхой бүлгийн эрх ашгийг илэрхийлдэг

## Намын чиг үүрэг

### Гадаад

- Иргэдийн улс төрийн идэвхийг сэргээх ( улс төржүүлэх )
- Улс төрийн эвсэл байгуулах
- Засгийн эрхийн төлөө тэмцэх
- Улс төрийн бодлого боловсруулах

### Дотоод

- Дэмжигчдээ гэгээрүүлэх
- Эгнээгээ өргөтгөх
- Анхан шатны байгууллага дэмжих , удирдах
- Намын элит хэсэг лидерийг бэлтгэж , төрүүлэх

## НАМЫН СИСТЕМ

Улс оронд тогтож буй улс төрийн дэглэм, олон түмний улс төрийн идэвхи, сонгуулийн хууль зэргээс шалтгаалж, улс төрийн намуудын тогтолцоо бүрдэнэ.

Нэг намын систем: Куба, Хойд Солонгос, Хятад ...

Хоёр намын систем: Англи, АНУ, Япон ...

Олон намын систем: Франц, Герман, Монгол ...

## НАМЫН ХЭВ МАЯГ, АНГИЛАЛ

Үүргийн шинж чанараар нь:

- олон нийтийн боловсон хүчний

Баримталж буй үзэл суртлын агуулгаар нь:

- коммунист, социалист, социал-демократ, либерал, консерватив, фашист

Явуулж буй үйл ажиллагааны шинж чанараар нь:

- аядуу, радикал (эрс шинэчлэлийн), экстремист (хурц)

Улс төрийн чиг баримжаагаар нь:

- зүүний, барууны, төвийг сахисан

Улс төрийн системд эзэлж байгаа байр сууриар нь:

- эрх баригч, сөрөг нам

Ямар үнэт зүйл хэрэгслийг эрхэмлэж байгаагаар нь:

- хувьсгалт, шинэчлэгч, уламжлалын

Зохион байгуулалт ба үйл ажиллагааны аргаар нь:

- ардчилсан төвлөрсөн

## Хяналтын асуулт, даалгавар:


1. Нийгмийн гишүүдийн дийлэнхийн итгэл үнэмшил, дадал заншилаар үүдэх улс төрийн хандлага гэж юу вэ?
2. Субъектээр удирдуулсан албан байгууллага .....
3. Нийгмийн анги бүлгүүдийн харилцаа, тэдний нийгмийн статусыг зохицуулах нь төрийн гадаад бодлого мөн.

### Үнэн Худал

1. Алмондын улс төрийн хэв маягуудыг тоочино уу?
2. Монгол улс ямар намын системт орон бэ?
3. Эрх мэдлийг субъектээр нь хэд ангилах вэ?
4. Улс төрийн эвсэл байгуулах нь намын ямар чиг үүрэг вэ?
5. Намын баримталж буй үзэл суртлаар нь хэрхэн ангилдаг вэ?

## Эх сурвалж:

1. “Нийгэм судлал” хичээлийн ерөнхий боловсролын сурах бичгүүд
2. Д.Буян “Нийгмийн тухай мэдлэг”. УБ., 2011
3. Орчуулсан Б.Батчулуун “Философи”. УБ., 2012
4. О.Пүрэв, С.Нямзагд, Р.Дарьхүү, Г.Сайнхишиг, Д.Буян, Т.Алтанцэцэг “Нийгмийн ухаан”. УБ., 2012
5. Б.Амгаланбаяр, Т.Сайхнаа “Хичээлүүдийн лавлах”. УБ., 2014



**Анхаарал хандуулсанд баярлалаа.**

